60

ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 22 өдөр Дугаар 2/04 Сайншанд

Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. **Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028” хөтөлбөрийг нэгдүгээр, “Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028” хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин”-г хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.**

2. **Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Тогтвортой хөгжсөн Сэврэй-2028” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан, шаардагдах зардлыг тооцоолж, санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж, хэрэгжилтийг хангаж, хууль, тогтоомжид заасан хугацаанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Батсайхан)-д үүрэг болгосугай.**

3. **Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллахыг бүх төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэдэд уриалсугай.**

ДАРГА Ч.ОГТБИШ

4624007095

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
2/04 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
“ТОГВОРТОЙ ХӨГЖСӨН СЭВРЭЙ-2028” ХӨТӨЛБӨР**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03/08 дугаар тогтоолоор батлагдсан “Өсөлттэй Өмнөговь” үйл ажиллагааны хөтөлбөр, сумын орон нутгийн ээлжит сонгуулиар олонхыг бүрдүүлсэн Өмнөговь аймгийн Сэврэй сумын Ардчилсан намын “Өсөлттэй Сэврэй–Нутгийн хишиг” мөрийн хөтөлбөрт суурилсан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа:

- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа-2050, Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль, Бүсчилсэн хөгжлийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, Монголын мянганы хөгжлийн зорилт, Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан үндэсний хөгжлийн цогц бодлого, Өмнөговь аймгийн “Хөгжлийн хөтөлбөр 2030” болон төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны ба захиргааны байгууллагуудаас улс, бүс, орон нутгийн хөгжилтэй холбогдуулан гаргасан тогтоол шийдвэр, төсөл хөтөлбөрүүдэд үндэслэн;

“Хүний хөгжлийг”-ийг дээдлэн “Боловсролын салбарын өсөлт”, “Эрүүл мэндийн салбарын өсөлт”, “Хөрөнгө оруулалт, эдийн засаг, хөдөө аж ахуйн салбарын өсөлт”, “Байгаль орчин аялал жуулчлалын салбарын өсөлт”, “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын өсөлт”-ыг 5 тэргүүлэх чиглэл болгон Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн 5 бодлогын хүрээнд 110 үйл ажиллагаа, 10 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгалаа.

МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

1. БОЛОВСРОЛ, СОЁЛЫН САЛБАРЫН ӨСӨЛТ
2. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ӨСӨЛТ
3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨСӨЛТ
4. БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨСӨЛТ
5. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ӨСӨЛТ

1. БОЛОВСРОЛ, СОЁЛЫН САЛБАРЫН ӨСӨЛТ

Иргэд, хүүхэд, залуус олон талт боловсролыг хүртээмжтэй олох нөхцөлийг бүрдүүлэн, тэдний гэр бүл, сургуулийн орчинд зөв төлөвшил, хүмүүжил, сурах арга барил эзэмшүүлэх замаар аль ч орны хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

1. Сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварыг хийнэ.
2. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засварыг хийнэ.
3. Сургуулийн анги танхим, дотуур байрыг шаардлагатай эд хөрөнгө, тоног төхөөрөмжөөр хангана.
4. Сургууль цэцэрлэгийн стандартын агуулахын барилгыг засварлаж ашиглалтад оруулна.
5. Цэцэрлэгийн анги танхимыг тохижуулж зөөлөн эдлэлийг шинэчлэх, шаардлагатай тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган, гадаа тоглоомын талбайг нэмж тохижуулан засварлан, гадаа хашааны аюулгүй байдлыг хангана.
6. Шинэ соёлын төвийн барилга барьж ашиглалтад оруулна.
7. Соёл урлагийн байгууллагыг тоног төхөөрөмж техник, хувцас хэрэгслээр хангана
8. Сумын музейг сан хөмрөгийг нэмэгдүүлнэ.
9. Ахмад настан, хүүхэд, залуучуудын спорт хөгжлийн төвийг барьж ашиглалтад оруулна.
10. **"Сайн багш-Оюунлаг сурагч"** хөтөлбөрийг хэрэгжүүлж суманд ажиллаж буй багш нарыг гадаад, дотоодод сурах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангана. Багш, боловсролын салбарын ажилтан, албан хаагчдын мэдлэг ур чадвар, заах аргаа тасралтгүй ахиулах боломжоор хангана.
11. Цэцэрлэг, сургуулийн хамран сургалтыг зохих түвшинд барьж, нэг багшид ногдох хүүхдийн тоог зохих түвшинд байлгах бодлого хэрэгжүүлэн, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
12. Төгсөлтийн шалгалт, элсэлтийн шалгалт, олимпиад, уралдаан тэмцээнд амжилт үзүүлж, өндөр оноо авсан багш, оюутан, сурагч, байгууллагыг урамшуулна.
13. Хүүхэд, залууст зориулсан компьютер програмчлал, математик, IQ, мэдээлэл зүй, техник загвар, STEM сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, иргэдийг бодлогоор дэмжинэ.
14. Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтуудыг тогтмол зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган дэмжиж ажиллана.
15. Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны чанар хүртээмжийг нэмэгдүүлж бага, дунд ангийн сурагчдад зориулсан "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
16. Сургалтын байгууллагын хөтөлбөрт олон улсын болон дотоодын шилдэг туршлага, шийдлийг нэвтрүүлж, "Сурагч солилцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
17. Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан аялалт хичээлийг хичээллүүлж, уламжлалт зан заншил, байгаль экологийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд сургалтын агуулгыг баяжуулан, байгаль орчны танин мэдэхүйн сургалт,зохион байгуулна. Байгаль хамгаалах сайн дурын клубийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
18. Багш нарын секц дугуйлан хичээллэх нөхцөлийг дэмжиж урамшуулан, хүүхдийг хөгжүүлэх бүх төрлийн дугуйлан секцийг тогтмолжуулж, уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулна.
19. **"Сэврэйн цом"** хүүхдийн бөхийн спортын наадмыг жил бүр зохион байгуулна.
20. Сумын Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах одон бөмбөгийн тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
21. Орон нутагт ажиллах сонирхолтой гадаад, дотоодын их дээд сургуульд суралцаж буй оюутанд дэмжлэг үзүүлж тэтгэлэгт хөтөлбөрт хамруулна.
22. Орчин үеийн стандартад нийцсэн нээлттэй номын сангийн үйл ажиллагааг тогтмолжуулна.
23. Соёлын үйлчилгээг ард иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэж, соёлын өвийн илрүүлэлт, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.
24. Нутгийн онцлог шингээсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг аялал

жуулчлалтай хослуулан хөгжүүлж, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих замаар соёлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

25. Бүх насны иргэд байнга сурч боловсрох, шинэ мэргэжил чадвар олж авах боломжоор ханган, төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулж иргэдийг мэдлэг чадвар эзэмшүүлнэ.

26. Тэмдэглэлт баяр ёслол, залуу гэр бүлүүдийн хуримын ёслол, ахмадын баяр, залуучуудын чуулга уулзалт, малчдын зөвлөгөөн, сумын аварга шалгаруулах урлаг, спортын уралдаан тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулна.

27. **"Ахмадын сургаал алтнаас үнэтэй"** хөтөлбөр хэрэгжүүлж, үндэсний өв соёл, урлаг, амьдрах арга ухаанд суралцах сургалтын агуулгыг бүрдүүлж амьдралын хэв маягаа сайжруулах сургалтуудыг ахмадуудыг түшиглэн зохион байгуулна.

2. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ӨСӨЛТ

Сумын хүн бүрийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эмчлэх, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэх, замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино

28. Эрүүл мэндийн төвийн 15 ортой шинэ барилгыг ашиглалтад оруулж тоног төхөөрөмжөөр хангана.
29. Эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, хүн амыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлж, өвчнийг эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлэн, хүнийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог тогтмол хийдэг, нотолгоонд болон хувь хүний онцлогт тохируулан урьдчилан сэргийлдэг эрүүл мэндийн үйлчилгээний шинэ хэлбэрийг бий болгоно.
30. Сумын "Эрүүл иргэн" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
31. Сумын эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний чанар, хүртээмж, техникийн хангалтыг сайжруулж туулах чадвар сайтай түргэн тусламжийн авто машинаар хангана.
32. Багийн эмнэлэг болон багийн эмчийн ажиллах нөхцөл бололцоог нэмэгдүүлэн багийн эмчийн шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөр хангана.
33. Орчин үеийн дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн оношилгооны лабораторийн хүчин чадлыг сайжруулан, сумандаа төрөл бүрийн шинжилгээг өгөх боломж нөхцөлийг хангаж ажиллан явуулын үзлэг шинжилгээний ажлыг зохион байгуулна.
34. Эх хүүхдийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэл болгон аймгийн "Эх хүүхдийн эрүүл мэнд" хөтөлбөрийг хэрэгжүүлэн чанар хүртээмжийг сайжруулан эх хүүхдийн өвчлөл эндэгдлийг бууруулна.
35. Бага насны хүүхдийг эрүүл чийрэг байхад зориулагдсан хүүхдийн сувиллыг ажиллуулж, аймгийн "Сүү тараг" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
36. Сумын 0-18 насны хүүхдийг урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.
37. Иргэдийн амны хөндий, шүдний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэн, гадаад дотоодын олон улсын сайн дурын байгууллагуудтай хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.
38. Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, эрүүл мэндэд эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйлс, нойрны дутагдлаас үүссэн мэдрэлийн ядаргаа, архи, тамхины хэрэглээг бууруулж, гар утсанд суурилсан стратегийн тусламжтайгаар иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолтыг дэмжих арга хэмжээг зохион байгуулна.
39. Элэгний шалтгаант өвчлөл, нас баралтыг бууруулах зорилгоор аймгийн

"Эрүүл элэг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

40. Уламжлалт сэргээн засах болон амны хөндийн эрүүл мэндийн мэргэжилтэнг бодлогоор бэлтгэн уламжлалт анагаах ухаан, шүдний кабинетыг ажиллуулна.

41. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлж, үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлнэ.

42. Эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн даатгалаар үйлчлэх үйлчилгээний нэр төрлийг олшруулж, эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлтөд хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

43. Бөөр, шээс, бэлгийн замаар халдварлах өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг өргөжүүлэн, иргэдийн бэлгийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлнэ.

44. Эмч, сувилагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд гадаад дотоодын сургалтуудад багаар нь сургаж бэлтгэх, ажлын байран дээрх сургалт, харилцан биенээсээ суралцах зэрэг сургалтын үр өгөөжтэй шинэлэг хэлбэрийг дэмжин хэрэгжүүлнэ.

45. Эрүүл мэндийн салбарын мэргэжилтний хангалтыг стандартад нийцүүлэн нэмэгдүүлж, амьдрах орчин, нийгмийн хамгааллыг сайжруулна.

46. Цахим эрүүл мэндийн системийг хөгжүүлж, үйлчилгээний шуурхай байдал, эмнэлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

47. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн, сувиллыг тогтмол зохион байгуулна.

3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨСӨЛТ

Мэдлэг боловсрол, мэдээллийн технологийн дэвшил, ногоон үйлдвэрлэлийн технологид суурилсан хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарыг дэмжиж тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоход оршино.

48. Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгч аж ахуй нэгж, иргэдтэй хамтран ажиллаж, тус салбараас олох орлогыг нэмэгдүүлэн сумын төсвийн орлогын тодорхой хувийг бүрдүүлнэ.

49. Ажлын байр нэмэгдүүлэн, өрхийн орлогыг өсгөх замаар хүртээмжтэй эдийн засаг бий болгоно. Иргэдийн мэдлэг, өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх орчин бүрдүүлж, зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлнэ улмаар дундаж давхаргыг тэлнэ. Сумын иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор **"Хөдөлмөрч Сэврэйчүүд"** дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Гэр бүл болон иргэд хамтран нийгэмд хорших маягаар хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.

50. Ажилд зуучлах үйлчилгээг эрчимжүүлж, ажил хайгч иргэдийг бүртгэлийн нэгдсэн системд бүртгэн иргэдийг байнгын болон түр ажлын байранд зуучилна.

51. **"Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих"** дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж сумын худалдаа үйлчилгээний бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

52. Эдийн засгаа тэлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж уул уурхайн компаниудад тодорхой бүтээгдэхүүн нийлүүлж орон нутгийн брэнд бүтээгдэхүүнтэй болно.

53. Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай зорилготой аймгийн "Чинээлэг малчин" хөтөлбөрийг хэрэгжүүлж малын үүлдэр угсааг сайжруулна.

54. Малчдын орлогыг нэмэгдүүлэх бэлчээрийн ашиглалтыг сайжруулах зорилгоор усгүй алслагдсан бэлчээрийг усжуулж хуучин худгуудыг засварлана.

55. Малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор мал эрүүлжүүлэх ариутгал туулгалт, вакцинжуулалтын ажлыг жил бүр зохион байгуулж шинээр мал угаалгын цэг байгуулж, хуучин мал угаалгын цэгүүдийг сайжруулна.

56. Залуу малчид, цөөн малтай өрхийг малжуулах төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, залуу малчдыг өвөлжөө бууцтай болгох ажлыг дэмжин ажиллана.
57. Малын тэжээлийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор бэлчээр хашиж хамгаалах, тэжээлийн ургамлын тариалалтыг нэмэгдүүлнэ.
58. Монголын говийн бахархал болсон хоёр бөхт тэмээний ашиг шим, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор тэмээнээс гарах ашиг шимт бүтээгдэхүүний үнэлэмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллан сумын Засаг даргын нэрэмжит хурдан торомны уралдаан зохион байгуулна.
59. Газар тариалан эрхлэх сургалтын бааз суурийг өргөжүүлэн сумын төвийн хүлэмжийн цогцолборын үйл ажиллагааг өргөжүүлнэ.
60. Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөний хүрээнд Хүнсний хангамж-аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүнсний хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.
61. Сумын төвд худалдаа, үйлчилгээний төв байгуулна.
62. Ахмадын өргөөг барьж ашиглалтад оруулж тохижуулна.
63. Сумын цагдаагийн хэсгийн барилгыг барьж ашиглалтад оруулна.
64. Сумын төрийн үйлчилгээний автомашины засвар үйлчилгээний автограш барина.
65. Сайншанд багийн төвийг шинээр барина.
66. Хоолт багийн төвийн барилгыг ашиглалтад оруулж тоног төхөөрөмжөөр хангана.
67. Даланзадгад-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай замаас Сэврэй сумын төв хүртэл /18км/, Сэврэй сумаас Хонгорын гол хүртэл /18км/ хатуу хучилттай авто замаар холбоно.
68. Баруун сумдын авто зам дагуу тээвэрчдийн үйлчилгээний төв байгуулна.
69. Суманд нисэх онгоц хүлээн авах нисэх буудал, хөөрч буух зурвас байгуулж, аялал жуулчлал, иргэний зориулалтын орон нутгийн нислэг үйлддэг болгоно.
70. Сумын төвийн ундны усны нэгдсэн эх үүсвэрт ус цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулж эрүүл ахуй аюулгүй байдлыг хангана.
71. Сумын төвийн ундны усны шинэ эх үүсвэрийг тогтоож усны нөөцийн байгууламжид холбоно.
72. Сумын төвд дэд бүтэц, орон сууц, эрчим хүч, дулаан, зам харилцааны бүтээн байгуулалт хийнэ. Сумын төвийн Хайрхан, Өлзийт, Энхтайван, Үсэгт хороолуудыг дэд бүтэцтэй холбох зураг төсвийг хийлгэнэ. Гэр хороолыг шаардлагатай цэгүүдэд дахин төлөвлөнө.
73. Сумын төв хөдөөгийн багуудын барилгын их засварийг хийж, шаардлагатай хуучин барилгуудыг дахин төлөвлөлтөд оруулж шинэчлэх буюу засварлана.
74. Сумын төвийн уурын зуухны хүчин чадлыг сайжруулах судалгаа тооцоог хийлгэнэ. Дэмд Од ОНӨААТҮГ-ийг ухдаг трактороор хангана.
75. Дулаан, цэвэр бохир усны төвлөрсөн шугам сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангана.
76. Сумын төвийн халаалтын шугамын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор томоохон барилга объектуудыг ялтсан бойлуураар холбоно.
77. Сумын иргэдийг орон сууцжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд иргэд, залуу гэр бүл, төрийн албан хаагч, эмч, багш, албан хаагчид, малчдыг орон сууцаар хангана.
78. Мэдээлэл харилцаа холбооны шинэ техник технологийн дэвшлийг бүх шатанд ашиглах боломжийг дэмжиж хөгжүүлнэ.
79. Сумын нийт айл өрх бүрд үүрэн холбооны утасны сүлжээ хүргэж, интернэтийн тархалтыг нэмэгдүүлнэ.
80. Сумын төвийн гудамжны гэрэлтүүлэг, хяналтын камерын урсгал засвар

үйлчилгээг тогтмол хийж хэвийн үйл ажиллагааг хангана.

81. Сумын засмал зам дагуух хилийн цэс дээр мэдээллийн цэг байгуулж, угтах, үдэх цэгийг тохижуулна.

82. Сумын төвд авто зогсоол байгуулна.

83. Хонгорын гол Нүдэн булаг амралтын газар, багийн төвүүдийг сэргээгдэх эрчим хүчээр хангана.

4. БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨСӨЛТ

Говь цөлийн бүсийн экологийн тэнцвэрийг хангах, хүрээлэн буй орчны унаган төрхийг хэвээр хадгалан үлдээх, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлээс байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны хэтийн бодлогын удирдлагыг орон нутгийн түвшинд оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх.

84. Сумын газар нутгийг орон нутгийн хамгаалалтад авсан шийдвэрүүдийн хугацаанд хяналт тавин ажиллаж, зуун хувь лицензгүй сум байх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

85. Хил орчмын аялал жуулчлалыг Хонгорын голын бүс нутгийн аялал жуулчлалтай холбож, нутгийн иргэдийн орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.

86. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх зорилгоор **“Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”**-ийг хэрэгжүүлж, аялал жуучлалын түр оператор, компаниудтай хамтран шинэ үйлчилгээг нэвтрүүлэн иргэд, малчид, бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

87. Элсний баяр, Хонгорын хурд, Хоолтын хурд, Тэмээний баяр, зэрэг уламжлал болсон эвент арга хэмжээг орон нутгийн иргэд, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж, шинэ санал санаачилгыг дэмжин ажиллана.

88. Хонгорын голын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

89. Хонгорын голын хогийн менежментийг сайжруулж хогийн машин, хог шатаах зуухаар хангана.

90. Сумын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн **“Ногоон сум”** сумын дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг талуудын оролцооны зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ. “Хашаандаа сайхан амьдарцгаая” аяныг өрнүүлж хашаандаа ашигт ургамал, жимс жимсгэнэ, хүнсний ногоо тариалах аяныг хэрэгжүүлнэ.

91. Түүх соёл, байгалийн өвт газруудын хамгаалалтыг орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан сайжруулна.

92. Задгай булаг шанд, баян бүрд, гадаргад ойрхон уст цэгүүдийг дайруулан ногоон бүс, хөв цөөрөм байгуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжинэ.

93. Хонгорын голд хөв цөөрөм байгуулж бүс нутгийн эко системийг хамгаална.

94. Сумын хог хаягдлын төвлөрсөн цэгийг шинээр байгуулна.

95. Хог хаягдлын менежментийг сайжруулж ангилан ялгаж дараагийн шатны боловсруулах үйлдвэрт хүргэхэд дэмжин ажиллана.

96. Говь цөлийн экосистем, биологийн олон янз байдал, экосистемд үзүүлдэг хүний буруутай үйлдлийн талаар сурагчид, залуучууд, иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, байгаль хамгаалах ухамсрыг төлөвшүүлнэ. Гар аргаар алт олборлосноос үүдэлтэй байгаль орчны бохирдлуудыг бууруулан байгаль орчинд хохирол учруулсан аливаа хуулийн этгээд, иргэнд зохих хариуцлагыг хүлээлгэж хохирлыг барагдуулна.

97. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр дамжуулан газрыг зохистой ашиглах газрын доройтол цөлжилтөөс сэргийлэн эвдрэлд орсон газрыг нөхөн

сэргээнэ.

98. Аймгийн баруун бүсийн мод үржүүлгийн газрыг нэмж тохижуулан үйл ажиллагааг өргөжүүлэн тогтмолжуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.

5. ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ӨСӨЛТ

Хувь хүний халдашгүй байдал, хууль ёсны эрх, ашгаа хамгаалуулах, шударгаар шийдвэрлүүлэх, гэм буруутай нь шүүхээр тогтоогдоогүй байхад ял зэм хүртэхгүй, хуулиас гадуур мөрдөн шалгагдахгүй байх, ялгаварлал, хүчирхийллээс ангид, айдасгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэн тэгш эрхтэй Сэврэйчүүд хөдөлгөөнийг өрнүүлэн 5С- /Сэтгэлтэй, Санаачилгатай, Самбаачилгатай, Сахилгатайгаар, Сэврэй сумаа хөгжүүлье/ -ийн зарчмыг хэрэгжүүлнэ.

99. Шаардлагатай мэргэжлийн боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэн бэлтгэх ажлыг уе шаттай хэрэгжүүлж, чадварлаг мэргэжилтнүүдийг сум, орон нутагт ирж ажиллах нөхцөлөөр ханган, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй боловсон хүчнийг бодлогоор дэмжин ажиллана.

100. Сумын удирдлага иргэдийн оролцоотой шийдвэр гаргадаг, тэр шийдвэр нь ил тод байдаг, шуурхай хүртээмжтэйгээр иргэдэд хүрдэг зарчмыг үргэлжлүүлнэ.

101. Хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн оролцоог хангасан, ил тод, ёс зүйтэй, шуурхай төрийн үйлчилгээг оновчтой бодлогоор удирдан, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан төрийн албан хаагчийн сахилга хариуцлага ёс зүй хандлагыг шинэ шатанд гаргаж иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлэн **“Сайн төрийн албан хаагч”** хөтөлбөрийг хэрэгжүүлэн иргэдийн эрэлтийг ханган төрийн албаны явуулын нэг цэгийн үйлчилгээг тогтмолжуулна.

102. **“Зөв бүхэн- Зөвхөн манай гэр бүлээс”** дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

103. Хүний эрх, иргэний оролцоо, байгаль орчин зэрэг чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын үйл ажиллагааг дэмжинэ. Төрийн зарим ажил, үйлчилгээг иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн өмчит байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлж, төрийн ачаалал, зардлыг хэмнэх бодлого хэрэгжүүлнэ.

104. Цахим орчны эрх зүйн харилцааг боловсронгуй болгох төрийн мэдээлэл үйлчилгээний и-монголиа, и оффис Өмнөговь цахим үйлчилгээнүүдийг хэрэгжүүлэн ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах зорилгоор Цахим засаглал бий болгоно. Хатан Сэврэйн мэдээ сонин, иргэдэд мэдээлэл хүргэх масс мессеж үйлчилгээг үргэлжлүүлэн ажиллуулна. Сэврэй сумын цахим хуудаснуудыг үргэлжлүүлэн ажиллуулж төрийн үйлчилгээний мэдээ мэдээллийг иргэдэд хүртээмжтэй хүргэж ажиллаж **“Мэдээлэлтэй иргэн хүчирхэг”** дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

105. Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган ажиллаж нас, хүйс, хөгжлийн ялгаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлалт, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн орчинд таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.

106. Хүүхэд, гэр бүлийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах явдлыг эрчимжүүлж, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настныг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн үеийн түр хамгаалах байрыг Цагдаагийн хэсгийг түшиглэн суманд байгуулна.

107. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах, сурах, орлогоо нэмэгдүүлэх, нийгмийн харилцаанд ороход нь тэгш, хүртээмжтэй, тогтвортой болгож, нийгмийн халамжийн тэтгэмжид зорилтот бүлгийн иргэдийг хамруулна.

108. Сумын ИТХ, Цагдаагийн хэсгийг түшиглэн иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох танхимыг тохижуулж, иргэдийг хууль эрх зүйн сургалт мэдээллээр

хангаж ажиллана.

109. Гэмт хэргээс зөрчил, зам тээврийн осол, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйлдлийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлж тодорхой төрлийн гэмт хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх оновчтой үйл ажиллагааг зохион байгуулна.

110. Сумын онцгой комиссыг онцгой байдлын үед ажиллах хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлэн нийгмийг хамарсан цар тахал, гал, үерийн аюул, газар хөдлөлт зэрэг байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, менежментийг сайжруулна.

"Хүний хөгжлийг"-ийг дээдлэн

1. **БОЛОВСРОЛ, СОЁЛЫН САЛБАРЫН ӨСӨЛТ**
   - Сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр-8 заалт
   - Ерөнхий боловсролын сургуулийн чиглэлээр-9 заалт
   - Соёл, спотрын чиглэлээр-10 заалт нийт "Боловсролын салбарын өсөлт"-ийн чиглэлээр 27 заалт
2. **ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ӨСӨЛТ**
   - "Эрүүл мэндийн салбарын өсөлт"-ийн чиглэлээр 20 заалт
3. **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСАГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ӨСӨЛТ**
   - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр-9 заалт
   - Хөдөө аж ахуйн чиглэлээр-8 заат
   - Хөрөнгө оруулалт, эдийн засгийн чиглэлээр-19 нийт 36 заалт
4. **БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ӨСӨЛТ**
   - Байгаль орчин аялал жуулчлалын салбарын өсөлтийн чиглэлээр 15 заалт
5. **ХҮНИЙ ЭРХИЙГ ДЭЭДЭЛСЭН ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ӨСӨЛТ**
   - Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын өсөлтийн чиглэлээр 12 заалттай Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт үндэслэн 5 бодлогын хүрээнд 110 үйл ажиллагаа, 10 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгалаа.

Дэд хөтөлбөрүүд

1. **"Сайн багш-Оюунлаг сурагч"** дэд хөтөлбөр
2. **"Ахмадын сургаал алтнаас үнэтэй"** дэд хөтөлбөр
3. **"Эрүүл иргэн"** дэд хөтөлбөр
4. **"Хөдөлмөрч Сэврэйчүүд"** дэд хөтөлбөр
5. **"Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих"** дэд хөтөлбөр
6. **"Аялал жуулчлалыг хөгжүүлэх" дэд хөтөлбөр**
7. **"Ногоон сум"** сумын дэд хөтөлбөр
8. **"Мэдээлэлтэй иргэн хүчирхэг"** дэд хөтөлбөр
9. **"Сайн төрийн албан хаагч" дэд хөтөлбөр**
10. **"Зөв бүхэн- Зөвхөн манай гэр бүлээс"** дэд хөтөлбөр

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дуг
22-ны өдрийн 2/04 дүгээр тогтоолын хоёрдугаар хав

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СЭВРЭЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ "ТОГТВОРТОЙ ХӨГЖСӨН СЭВРЭЙ-2028" ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

№	Бодлогын үндэслэл	Үйл ажиллагаа	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин				Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хар байгу
						он	түвшин	2025	2026	2027	2028			Үндсэн
Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн														
НЭГ. БОЛОВСРОЛ, СОЁЛЫН САЛБАРЫН ӨСӨЛТ														
1	Иргэд, хүүхэд, залуус олон талт боловсролыг хүртээмжтэй олох нөхцөлийг бүрдүүлэн, тэдний гэр бүл, сургуулийн орчинд зөв төлөвшил, хүмүүжил, сурах арга барил эзэмшүүлэх замаар аль ч орны хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх.	Сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын их засварыг хийнэ.	Хүүхдийн сурч боловсрох орчин сайжирна.	Орчин нөхцөлийг сайжруулсан	Тоо	2024	1	1				Засвар хийгдсэн байдлаар тооцно	Жил бүр	СЗДарга
2		Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны их засварыг хийнэ.	Сурагчдын амьдрах орчин сайжирна.	Орчин нөхцөлийг сайжруулсан	Тоо	2024	1	1				Засвар хийгдсэн байдлаар тооцно	Жил бүр	СЗДарга
3		Сургуулийн анги танхим, дотуур байрыг шаардлагатай эд хөрөнгө, тоног төхөөрөмжөөр хангана.	Сургууль, дотуур байрны тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Орчин нөхцөлийг сайжруулсан	Тоо	2024	1		1	1		Тоног төхөөрөмжөөр хангагдсан тоогоор тооцсон	Жил бүр	СЗДарга
4		Сургууль цэцэрлэгийн стандартын агуулахын барилгыг засварлаж ашиглалтад оруулна.	Шаардлага хангасан агуулахтай болно.	Агуулахын тоо	Тоо	2024	0			1	1	Агуулахын тоогоор	Жил бүр	СЗДарга
5		Цэцэрлэгийн анги танхимыг тохижуулж зөөлөн эдлэлийг шинэчлэх, шаардлагатай тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнээр ханган, гадаа тоглоомын талбайг нэмж тохижуулан засварлан, гадаа хашааны аюулгүй байдлыг хангана.	Цэцэрлэг тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.	Орчин нөхцөлийг сайжруулсан анги танхим	Хувь	2024	0		4		4	Тоног төхөөрөмжөөр хангагдсан тоогоор тооцсон	Жил бүр	СЗДарга
6		Шинэ соёлын төвийн барилга барьж ашиглалтад оруулна.	300 хүний суудалтай соёлын төв барина.	Барилгын гүйцэтгэл	Хувь	2024	0		50	100		Барилгын ажлын гүйцэтгэлийн хувиар тооцсон.	Жил бүр	СЗДарга
7		Соёл урлагийн байгууллагыг тоног төхөөрөмж техник, хувцас хэрэгслээр хангана	Шинэ соёлын төвийн шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	Тоног төхөөрөмжийн хангалт	Хувь	2024	0			100		Тоног төхөөрөмжөөр хангагдсан тоогоор тооцсон	Жил бүр	СЗДарга

8	Сумын музейг сан хөмрөгийг нэмэгдүүлнэ.	Музейн үзмэрийн тоо нэмэгдсэн байна.	Нэмэгдсэн үзмэрийн тоо	Тоо	2024	2	3	3	3	3	Нэмэгдсэн үзмэрийн тоогоор	Жил бүр	Соёлын те	Музей
9	Ахмад настан, хүүхэд, залуучуудын спорт хөгжлийн төвийг барьж ашиглалтад оруулна.	Залуучуудын спорт хөгжлийн төвийг барьж ашиглалтад оруулна.	Барилгын гүйцэтгэл	Хувь	2024	0				100	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувиар тооцно	Жил бүр	СЗДарга	ЗДТГ
10	**“Сайн багш-Оюунлаг сурагч”** хөтөлбөрийг хэрэгжүүлж суманд ажиллаж буй багш нарыг гадаад, дотоодод сурах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангана. Багш, боловсролын салбарын ажилтан, албан хаагчдын мэдлэг ур чадвар, заах аргаа тасралтгүй ахиулах боломжоор хангана.	Багш сурагчдын ур чадвар нэмэгдсэн байна.	Хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	Хувь	2024	0	50	70	90	100	Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар	Жил бүр	ЕБС	СӨБ
11	Цэцэрлэг, сургуулийн хамран сургалтыг зохих түвшинд барьж, нэг багшид ногдох хүүхдийн тоог зохих түвшинд байлгах бодлого хэрэгжүүлэн, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Тойргийн хүүхдийг сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулсан байна.	Хамрагдсан багш, ажилтан	Гүйцэтгэлийн хувиар	2024	100	100	100	100	100	Гүйцэтгэлийн хувиар	Жил бүр	ЕБС	СӨБ
12	Төгсөлтийн шалгалт, элсэлтийн шалгалт, олимпиад, уралдаан тэмцээнд амжилт үзүүлж, өндөр оноо авсан багш, оюутан, сурагч, байгууллагыг урамшуулна.	Элсэлтийн шалгалт болон Олон улсын шалгалтын үнэлгээнд өндөр оноо авсан суралцагчдын тоог нэмэгдүүлнэ.	ЭШ болон ОУ шалгалтад өндөр үнэлгээ авсан сурагчид	Гүйцэтгэлийн хувиар	2024	100	100	100	100	100	ЭШ болон олон улсын шалгалтад өндөр үнэлгээ авсан сурагчдын тоог өссөн дүнгээр тооцсон.	Жил бүр	ЕБС	ЗДТГ
13	Хүүхэд, залууст зориулсан компьютер программчлал, математик, IQ, мэдээлэл зүй, техник загвар, STEM сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, иргэдийг бодлогоор дэмжинэ.	Боловсролын салбарын сургалтын чанарыг дээшлүүлнэ.	СӨБ-ын гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	2024	100	100	100	100	100	СӨБ-ын гүйцэтгэлийн үнэлгээ	Жил бүр	СӨБ	ЗДТГ
14	Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтуудыг тогтмол зохион байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган дэмжиж ажиллана.	Зуны цэцэрлэгийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Зуны цэцэрлэгт хамрагдсан хүүхэд	Тоо	2024	28	30	30	30	30	Зуны цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоогоор тооцсон.	Жил бүр	СӨБ	ЗДТГ

15	Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны чанар хүртээмжийг нэмэгдүүлж бага, дунд ангийн сурагчдад зориулсан "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Сурагчдын эрүүл мэнд, идэвхтэй сурах үйл ажиллагааг дэмжин, хоол тэжээлийн хомсдолд орох, ходоодны өвчлөлөөс сэргийлнэ	"Үдийн хоол" хөтөлбөрт хамрагдсан сурагчид	Тоо	2024						Хөтөлбөрт хамрагдсан сурагчдын тоогоор тооцсон	Жил бүр	СЗДарга	ЕБС
16	Сургалтын байгууллагын хөтөлбөрт олон улсын болон дотоодын шилдэг туршлага, шийдлийг нэвтрүүлж, "Сурагч солилцоо" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Хөрш зэргэлдээ бусад сум аймагт сурагчдыг явуулж хувь хүний хөгжлийг дэмжинэ.	Хамрагдсан сурагчид	Тоо	2024	0	5	5	10	10	Хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоогоор тооцсон.	Жил бүр	ЕБС	ЗДТГ
17	Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдэд зориулсан аялалт хичээлийг хичээллүүлж, уламжлалт зан заншил, байгаль экологийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлд сургалтын агуулгыг баяжуулан, байгаль орчны танин мэдэхүйн сургалт,зохион байгуулна. Байгаль хамгаалах сайн дурын клубийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.	ЕБС-н сурагчдыг эх орон, байгаль орчноо хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлнэ.	Хамрагдсан сурагчид	Тоо	2024	208	210	210	210	210	Тухайн жилд хамрагдсан сурагчдын тоогоор тооцно.	Жил бүр	ЕБС	СӨБ
18	Багш нарын секц дугуйлан хичээллэх нөхцөлийг дэмжиж урамшуулан, хүүхдийг хөгжүүлэх бүх төрлийн дугуйлан секцийг тогтмолжуулж, уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулна.	Хүүхдэд зөв эерэг хандлагыг төлөвшүүлж, хөгжил оролцоо, авьяас чадварыг дэмжинэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	100	100	100	100	100	Жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар тооцно	Жил бүр	ЕБС	ЗДТГ
19	"Сэврэйн цом" хүүхдийн бөхийн спортын наадмыг жил бүр зохион байгуулна.	Бөхийн баяр арга хэмжээг жил бүр зохион байгуулж хүүхдийн авъяас чадварыг нэмэгдүүлнэ.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	100	100	100	100	100	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар тооцно	Жил бүр	ЕБС	ЗДТГ
20	Сумын Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах одон бөмбөгийн тэмцээнийг жил бүр зохион байгуулна.	Жил бүр аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна.	Тэмцээний тоо	Тоо	2024	0	1	1	1	1	Зохион байгуулсан тэмцээний тоогоор	Жил бүр	СЗДарга	ЕБС

21		Орон нутагт ажиллах сонирхолтой гадаад, дотоодын их дээд сургуульд суралцаж буй оюутанд дэмжлэг үзүүлж тэтгэлэгт хөтөлберт хамруулна.	Их дээд сургуульд суралцах, мэргэших суралцагчдыг нэмэгдүүлнэ.	Зохион байгуулсан арга хэмжээ	Тоо	2024	13	15	15	15	15	Арга хэмжээний тоогоор тооцсон	Жил бүр	НБМ	ЗДТГ
22		Орчин үеийн стандартад нийцсэн нээлттэй номын сангийн үйл ажиллагааг тогтмолжуулна.	Номын санг тохижуулж, орчин нөхцөлийг сайжруулна.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	100			100		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар тооцно	Жил бүр	Соёлын төв	Номын сан
23		Соёлын үйлчилгээг ард иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэж, соёлын өвийн илрүүлэлт, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.	Соёлын үйлчилгээг иргэдэд хүргэж солёын өвийн хадгалалт хамгаалалт сайжирна.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	100	100	100	100	100	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар тооцно	Жил бүр	Соёлын төв	Иргэд
24		Нутгийн онцлог шингээсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих замаар соёлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Нутгийн онцлог бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Бүтээгдэхүүний төрөл	Хувь	2024	100	100	100	100	100	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	Жил бүр	Соёлын төв	ЗДТГ
25		Бүх насны иргэд байнга сурч боловсрох, шинэ мэргэжил чадвар олж авах боломжоор ханган, төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулж иргэдийг мэдлэг чадвар эзэмшүүлнэ.	Иргэд, бүх нийтийн боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, иргэдийг дэмжинэ.	Хөтөлберийн үйл ажиллагааны хэрэгжилт	Хувь	2024	80	100	100	100	100	Хөтөлберийн үйл ажиллагааны тухайн жилийн хэрэгжилтийн хувь	Жил бүр	ЕБС	НТББагш
26		Тэмдэглэлт баяр ёслол, залуу гэр бүлүүдийн хуримын ёслол, ахмадын баяр, залуучуудын чуулга уулзалт, малчдын зөвлөгөөн, сумын аварга шалгаруулах урлаг, спортын уралдаан тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулна.	Малчдын зөвлөгөөн, сумын аварга шалгаруулах урлаг, спортын уралдаан тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулна.	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	2024	5	5	5	5	5	Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор тооцно	Жил бүр	НБМ	ЗДТГ
